

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020-05-18

Тендерийн дугаар: МРЦМ/202004446

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээ хийх аргачлалын дагуу Үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй нийт барилга, байгууламж буюу үл хөдлөх хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, газарт дахин үнэлгээ хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа уурхай, салбар нэгжийн өмчлөлд буй хөрөнгөд хамаарна. Үүнд:

- “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захиргаа /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг/
- “Бор-Өндөр” УБҮ /Хэнтий аймаг Бор-Өндөр сум/
- “Шижир алт” алтны үйлдвэр /Төв аймаг Заамар сум Хайлааст баг/

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ.

Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Ажиллах хүчний танилцуулга,
- Хөрөнгийн дахин үнэлгээ хийх эрх бүхий бүх ажиллагсдын тусгай зөвшөөрөл.
- Хөрөнгийн дахин үнэлгээ хийх эрх бүхий бүх ажиллагсдын тусгай зөвшөөрөл хүчинтэй, цуцлагдаагүй байгаа тухай Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын албан тодорхойлолт.
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/,
- 2018, 2019 онуудад ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн актын хамт
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ

Сонирхсон этгээд мэдүүлгээ **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар** 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр
Утас: 450060-186, Факс: 458380 Имэйл хаяг: mailbox@monros.mn